

**2017 ОНЫ 10 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

№	Товч агуулга	Хэрэгжилт
1	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсантай холбогдуулан НИТХ-ын Тэргүүлэгчдийн болон Дэд хороо, Намын бүлгийн хуралдаанаар хэлэлцэх тул Нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагуудын удирдлагууд идэвхтэй оролцох.	Нийслэлийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн урьдчилсан шатны хэлэлцүүлэгт газрын дарга Д.Баянбат мөн хэлтсийн дарга нар оролцсон.
2	Нийслэлийн хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд инженерийн байгууллагуудын ажлын гүйцэтгэлтэй танилцсан, иймд мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд өвлийн их ачааллын үед иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарах, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авах шуурхай бригадуудаа бэлэн байлгах. /Захирагчийн ажлын алба, Дүүргүүд, Хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа байгууллагууд/	-
3	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөөний хүрээнд ажил хариуцсан байгууллагууд хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэх, үр дүнг танилцуулах цаашид хэрэгжүүлэх ажлуудад онцгой анхаарч ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Дүүрэг, Хэрэгжүүлэгч агентлаг, Харьяа газар/	-
4	Нийслэлийн өдрийг угтаж энэ сард зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээнд иргэд олон нийтийг хамруулах, байгууллагууд өөрсдөө идэвхтэй оролцох, ойг угтаж мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд тохижилт, хог цэвэрлэгээ, гудамж замын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх, сэргээх, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна хаягжилт, өнгө үзэмжийг сайжруулах зэрэг ажлуудыг зохион байгуулах. /НЗДТГазар, Захирагчийн ажлын алба, Дүүргүүд, Хэрэгжүүлэгч агентлаг, бусад харьяа газрууд/	Нийслэлийн өдрийг угтаж газрын хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 6 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу арга хэмжээ зохион байгуулж байна.
5	Нийслэлийн өдрийг угтаж Улаанбаатар хотын замын хөдөлгөөний хэт ачааллыг бууруулах зорилгоор “Миний сонголт-Нийтийн тээвэр” аяныг дэмжиж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд идэвхтэй оролцох. /Нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагууд/	Миний сонголт нийтийн тээвэр аяны хүрээнд нийтийн тээврийн смарт картгүй албан хаагчдын судалгаа гаргаж холбогдох газарт нь хүргүүлсэн. Газрын хэмжээнд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих өдрийг Пүрэв гарагаар сонгон нийтийн тээврээр үйлчлүүлж байна.